

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МОРИН УРАЛДААНЫ ДҮРЭМ

2022 оны 03 дугаар
сарын 20-ны өдөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Дүрмийн зорилт

1.1. Энэхүү дүрмийн зорилт Монгол наадам, түүний нэг бүрэлдэхүүн болох үндэсний морин уралдаан, түүнийг дагасан соёлын өвийг хадгалах, хэрэглэх, хамгаалах, өвлүүлэх, үндэсний морин уралдаан зохион байгуулахтай холбоотой үүсэх бүхий л харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хамрах хүрээ

2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа үндэсний морин уралдаанд, Монголын Үндэсний Морин Уралдаан, Уяачдын Холбоо /цаашид "Үндэсний холбоо" гэх/, түүний орон нутаг дахь салбар холбооноос зохион байгуулах үндэсний морин уралдаанд энэхүү дүрэм үйлчилнэ.

3 дугаар зүйл. Нэр томъёоны тайлбар

3.1. "Монгол наадам" гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэлгэдсэн улс, аймаг, нийслэл, сум (дүүрэг)-нд жил бүр нэгэн зэрэг тэмдэглэдэг Нэгдсэн Үндэсний байгууллагын ЮНЕСКО-гийн Дэлхийн хүн төрөлхтний төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн биет бус соёлын өв Үндэсний их баяр наадмын уламжлалт эрийн гурван наадам /үндэсний бөхийн барилдаан, үндэсний морин уралдаан, үндэсний сурын харваа/-ыг хэлнэ.


3.2. "Үндэсний морин уралдаан" гэж үндэсний уламжлалт, ёс заншилд тулгуурлан нутгийн уугуул монгол үүлдрийн адууг азарга, их нас, соёлон, хязаалан, шүдлэн, даага гэсэн зургаан насны ангиллаар бага насны хүүхдээр унуулж, зохион байгуулж буй морин уралдааныг хэлнэ.

3.3. "Монгол үүлдрийн адуу" гэж Монгол орны байгаль, газар зүй, цаг уурын өвөрмөц нөхцөлд дасан зохицож амьдрах чадвартай, жилийн дөрвөн улиралд бэлчээрийн маллагаанд байдаг, толгой том, богино бүдүүн хүзүүтэй, аман хүзүү, чахалзуураар бүдүүн, монхордуу хамартай, чийрэг бие цогцостой, цомбон туурайтай, өтгөн дэл сүүлтэй, бат бөх ястай, тэсвэр хатуужил, уналга, эдэлгээ даах чадвар сайн, арчилгаа шаарддаггүй, өвчин бага тусдаг¹, гадаад улсын өөр үүлдрийн адуутай үржүүлээгүй² монгол нутгийн уугуул адууг хэлнэ.

¹ Мал аж ахуй. Монгол үүлдрийн, омгийн адуу MNS 4099:2020

² Малын генетик нөөцийн тухай хуулийн 12.2-т "Монгол мал, тэдгээрээс гаралтай үүлдэр, омгийн малыг тухайн бүс нутагт цэврээр үржүүлж, уугуул орчинд хамгаална"

Нэмэлт тайлбар: Монгол адуу биологи, экологи, эталоги, аж ахуйн олон өвөрмөц шинж чанарыг хадгалсан бөгөөд эдгээрийн шинж чанарын зарим нь бусад үүлдрийн адуунд байдаггүй. Үүнд:



1. Монгол адуу нь давхиж байхдаа унаж байгаа хүүхэд, эзнээ мэдрэх чадвар илүү сайн
2. Монгол адуу нь газрын гадаргуу, замын бартаа саадыг мэдрч хурдлах чадвар илүү сайн
3. Үрсэн төлсөх
4. Сүрэглэн ижилсэх
5. Бэлчээрээ сонгон нутагших
6. Шинэ орчинд хялбархан дасаж зохицох
7. Эзэндээ номхон, алс холоос эргэж нутгаа гүйх
8. Цаг агаарын өөрчлөлтийг урьдчилан мэдрэх
9. Азарга бүр тодорхой тооны гүү хураах
10. Эхээ гишгэхгүй байх, өөрийн үр төл байдсаа сүргээс хасах
11. Сүргээ хамгаалах, дагуулах
12. Төрөлхийн өвчлөмтгий биш, тэсвэр хатуужил сайтай
13. Явсан зам, уусан ус, бэлчээрлэж дассан нутаг, бэлчээрээ мартдаггүй
14. Мэдрэхүйн эрхтний хүлээн авах чадвар /анализатор/ бусад малынхаас илүү сайн хөгжсөн учир болзолт рефлекс амархан үүсдэг
15. Эзнийхээ зан араншин, үйл хөдөлгөөнөөр ямар үйлдэл хийх гэж байгааг мэддэг өвөрмөц онцлогтой.
16. Сонсгол, харах чадвар, соргог байдал, үнэрлэх эрхтнүүд сайн хөгжсөн.
17. Дуу хоолойны өнгө аясыг амархан ялгадаг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ МОРИН УРАЛДААНЫ АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

4 дугаар зүйл. Үндэсний морин уралдааны насны ангилал³

- 4.1. Азарга /үржүүлгийн зориулалтаар сонгосон агтлаагүй 60-аас дээш сарын настай монгол үүлдрийн адууг/
- 4.2. Их нас /нас гүйцсэн агталсан монгол үүлдрийн адууг/
- 4.3. Соёолон /49-60 сарын настай эр монгол үүлдрийн адууг/
- 4.4. Хязаалан /37-48 сарын настай эр монгол үүлдрийн адууг/
- 4.5. Шүдлэн /25-36 сарын настай эр монгол үүлдрийн адууг/
- 4.6. Даага /13-24 сарын настай эр монгол үүлдрийн адууг/

5 дүгээр зүйл. Үндэсний морин уралдааны зэрэглэл

- 5.1. Үндэсний их баяр наадмын үндэсний морин уралдаан
- 5.2. Үндэсний Холбооны "МОНГОЛ МАГНАЙ" үндэсний морин уралдаан
- 5.3. Үндэсний Холбооны аймаг дахь салбар холбооноос аймгуудын дунд зохион байгуулах "ДАНШИГИЙН МАГНАЙ" үндэсний морин уралдаан
- 5.4. Үндэсний Холбооны аймаг дахь салбар холбооноос тухайн аймгийн хэмжээнд зохион байгуулах "АЙМГИЙН МАГНАЙ" үндэсний морин уралдаан
- 5.5. Үндэсний холбооны суман дахь салбар холбооноос сумынхаа хэмжээнд зохион байгуулах "СУМЫН МАГНАЙ" үндэсний морин уралдаан

³ Мал аж ахуй. Монгол үүлдрийн, омгийн адуу MNS 4099:2020

5.6. Орон нутгийн үндэсний морин уралдаан

6 дугаар зүйл. Үндэсний морин уралдааны насны ангилалын уралдах зай

6.1. Үндэсний морин уралдааны насны ангилалаар зуны уралдах зай

Азарга	23-24 км
Их нас	25-26 км
Соёолон	23-24 км
Хязаалан	17-18 км
Шүдлэн	13-14 км
Даага	11-12 км

6.2. Үндэсний морин уралдааны насны ангилалаар хаврын уралдах зай

Азарга	15-17 км
Их нас	17-19 км
Соёолон	15-17 км
Хязаалан	9-11 км
Шүдлэн	7-9 км
Даага	5-7 км

ГУРАВДУГААР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ МОРИН УРАЛДААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7 дугаар зүйл. Үндэсний морин уралдааны зохион байгуулагч нь Монголын Үндэсний Морин Уралдаан, Уяачдын Холбоо, түүний орон нутаг дахь салбар холбоо байх бөгөөд үндэсний морин уралдааны товыг зохион байгуулагч 30-аас доошгүй хоногийн өмнө тогтоож, www.mongolnaadam.mn, www.mongoladuu.mn вэб сайтаар олон нийтэд зарлана.

- 7.1. уралдаан болох огноо
- 7.2. уралдаан болох байршил, газар
- 7.3. уралдааны ангилал, зэрэглэл
- 7.4. уралдах морьдын насны ангилал,
- 7.5. уралдах зай
- 7.6. бүртгэлийн хураамжийн хэмжээ
- 7.7. бай шагналын хэмжээ

8 дугаар зүйл. Энэхүү дүрмийн 5 дугаар зүйлд заасан зэрэглэлийн үндэсний морин уралдааныг зохион байгуулагч нь Монголын Үндэсний Морин Уралдаан, Уяачдын холбооны Удирдах Зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсны дараагаар олон нийтэд зарлан, зохион байгуулах комисс томилж, журам баталж хэрэгжүүлнэ.

9 дугаар зүйл. Энэхүү дүрмийн дагуу зохион байгуулагдах үндэсний морин уралдаанд тавих хөндлөнгийн хяналтыг дээд шатны салбар холбооноос бүрэлдэхүүнтэйгээр хяналтын комисс томилж, уралдаан зохион байгуулагч ажлаа хийх боломжоор хангана. Хяналтын комисс тухайн уралдааны явцад хяналт тавьж, дүрмийн хэрэгжилэнд дүгнэлт гаргаж, тайланг дээд шатны үндэсний холбоонд ирүүлнэ.

10 дугаар зүйл. Уралдаан зохион байгуулах комиссын эрх, үүрэг

10.1. Комиссын эрх

10.1.1. Үндэсний морин уралдаанд оролцогчидоос энэ дүрмийг биелүүлэхийг шаардах

10.1.2. уралдааны журам батлах

10.1.3. Гарааны цагаас хоцорсон морийг уралдаанаас хасах.

10.1.4. Байгаль, цаг уурын давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл, үзэгдэх орчин хязгаарлагдсан, цаг оройтсон зэрэг үүссэн тохиолдолд уралдааныг түр хойшлуулах, цуцлах

10.1.5. Уяачдаас морьдоо тогтоосон цагт мордуулахыг шаардах

10.1.6. Үндэсний морин уралдааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулах зөвшөөрөл олгох

10.1.7. Энэ дүрмийг зөрчсөн этгээдэд хариуцлага оногдуулах эрхтэй

10.1.8. бусад

10.2. Комиссын үүрэг

10.2.1. Үндэсний морин уралдааны хөтөлбөр батлах

10.2.2. Уралдааны хөтөлбөр, цагийн хуваарийн дагуу зохион байгуулах

10.2.3. Уралдах нас бүрийн гарааны зурхайг тогтоох, гарааны төхөөрөмж байршуулах,

10.2.4. Морьдын хурдлах чадварт сөрөг нөлөө үзүүлэхээргүй уралдааны замыг сонгох, засварлах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах

10.2.5. Уралдах морьдыг гарааны зурхайд бүрэн хүргэж, зэрэг эргүүлэх

10.2.6. Уралдааны явцад бэртэж гэмтсэн хүүхэд, морьдод эмнэлгийн тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах

10.2.7. Хүсэлт, гомдол, маргаантай асуудлыг хууль, дүрмийн дагуу шийдвэрлэх

10.2.8. Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах

10.2.9. Дарга, гишүүд хариуцсан ажил, үүргийн хуваарийн дагуу уралдааныг дуустал ажиллаж, тайлан гаргаж өгөх үүрэгтэй.

10.2.10. бусад


11 дүгээр зүйл. Үндэсний морин уралдаанд уралдах нутгийн уугуул монгол үүлдрийн адууны бүртгэл

11.1. Үндэсний морин уралдаанд Монголын Үндэсний Морин Уралдаан, Уяачдын Холбооны гишүүн уяач нь энэхүү дүрмийн 3.3-т заасан монгол үүлдрийн адууг үндэсний холбооны дэргэдэх Монголын адууны бүртгэлийн төв / www.mongoladuu.mn /-д уяач бүртгүүлэх адууны угшил гарвалыг шударга мэдүүлэн цахим вэб сайт ашиглан, ил тод бүртгүүлнэ.

11.2. Монголын Адууны бүртгэлийн төвд нутгийн уугуул монгол үүлдрийн адууг бүртгүүлэхэд тавигдах шаардлага. Үүнд:

1.	Адууны мэдээллийн хэсэгт	1. Бүртгэлийн дугаар 2. Адууны оноосон нэр 3. Зүс 4. Хүйс
----	--------------------------	--

		5. Төрсөн он, нас 6. Байршил /адуу нутаглаж байгаа газар/ 7. Биологийн дээж авч буй богино бичлэг, 8. Биологийн дээжний хариу оруулах хэсэг, зураг оруулах боломжтой 9. 4 талаас авсан стандарт зураг, содон шинж тэмдэг оруулсан нэмэлт зураг оруулах боломж 10. Унаган эзэний нэр, аймаг сум 11. Тамганы нэршил, дүрс зураг оруулах хэсэг 12. Угшилын тайлбар 13. Эцэг, эхийн дээд 4 үеийн зураглал бүхий хүснэгт 14. Үзүүлсэн амжилт 15. Нэмэлт тайлбар текст оруулах хэсэг
2.	Адууны өмчлөгч	1. Бүртгэлийн дугаар 2. Ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр 3. Зураг оруулах 4. Аймаг, сум, цол оруулах 5. Утасны дугаар 6. Адууний үнэлгээ, /худалдан авсан үнэ/ 7. Нэмэлт тайлбар текст оруулах хэсэг
3.	Бүртгэлийн мэдээллийн хэсэгт	1. Бүртгэлийн дугаар 2. Чипний дугаар 3. Бүртгэсэн байгууллагын тамга, тэмдэг, гарын үсэг 4. Өмчлөгчийн өөрчлөлтийн мэдээлэл 5. Биологийн дээж авсан баримт 6. Хуваарьт тарилганд хамрагдсан байдал 7. Нэмэлт тайлбар текст оруулах хэсэг



11.3. Бүртгэгдсэн нутгийн уугуул монгол үүлдрийн адуу нь Монгол Улсын нутаг дэвсгэрт зохион байгуулагдах үндэсний морин уралдаанд уралдах эрхтэй.

11.4. Бүртгэгдсэн адууны угшил гарвалын талаар худлаа, зөрүүтэй мэдээлэл бүхий хөндлөнгийн гомдол ирүүлсэн тохиолдолд энэхүү дүрмийн дагуу гомдлыг шийдвэрлэж, шаардлагатай тохиолдолд бүртгэлийг хүчингүй болгоно.

11.5. Бүртгэгдсэн нутгийн уугуул монгол үүлдрийн адууг нэн даруй боломжит хугацаанд Монгол адууны генетикийн судалгаа хийсэн шинжлэх ухааны байгууллагатай хамтран ажиллах замаар геномын өвөрмөц дарааллын ялгаагаар нь бүртгэлжүүлэлтээ сайжруулна.

12 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан шаардлага хангаагүй хүүхдийг үндэсний морин уралдаанд оролцуулахгүй.

13 дугаар зүйл. Уяач зохион байгуулах комиссоос олгосон дугаарыг хүүхдийн хувцсан дээр харагдахуйц байдлаар бэхэлж, бүртгүүлсэн морийг уралдуулах эрхтэй.

14 дугаар зүйл. Үндэсний холбооны мэдээллийн санд бүртгүүлээгүй адуу үндэсний морин уралдаанд уралдах эрхгүй.

15 дүгээр зүйл. Морьдыг мордуулах

15.1. Уралдах морины эзэн, уяач нь үндэсний холбооны мэдээллийн санд бүртгэлтэй эсэхийг шалгана.

15.2. Уралдах морьд Монголын Адууны бүртгэлийн төвд бүртгүүлсэн эсэх болон насны ангилалд тохирсон эсэхийг шүдлэж шалгана.

15.3. Тухайн насны ангиллын уралдаанд нутгийн уугуул монгол үүлдрийн адуунд нийцээгүй, шүдээр тохироогүй, мэдээллийн санд бүртгүүлээгүй морьдийг тусгай хашаанд оруулж, уралдаанч хүүхдэд олгосон дугаарыг хурааж, уралдаанд оролцуулахгүй.

15.4. Морьдыг мордуулах үйл явцыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн сүлжээгээр шууд дамжуулж болно.

15.5. Уралдаанд морь тавиач явуулж болох бөгөөд тусгай дугаартай, эмээлтэй, сүүлийг шуугаагүй монгол адуу унасан байна.

15.6. Морь тавиач нь дүрэм, журмыг зөрчих, бусдад аюул учруулах, уралдааныг будлиантуулах, гарааны төхөөрөмжинд орох, гараан дээрээс уралдах морьдыг шахах, хөөхийг хориглоно. Хориглосон энэхүү заалтыг зөрчсөн тохиолдолд учирсан хохирлыг төлүүлж, тухайн тавиачын уралдуулсан морийг уралдаанаас хасна.

15.7. Тээврийн хэрэгслээр уралдах морьдыг хөтөлж явахыг хориглоно.

16 дугаар зүйл. Гарааны үеийн зохион байгуулалт

16.1. Уяачид уралдах морьдоо барианы газар авчирч цуглармагц төрийн далбаа, эсхүл үндэсний холбооны тугийг мандуулсан манлайлагч бүх морьдыг дагуулан, асрыг нар зөв гурав тойроод нэгдсэн журмаар гарна.

16.2. Морьдыг гарааны зурхайд хүргэж эргүүлэхийг зохион байгуулах комиссийн дарга, тухайн насны морин даамал, дэд даамал, тусгайлан бэлтгэсэн морьтой хүмүүс, хүн эмнэлэг, мал эмнэлгийн түргэн тусламжийн ажилтнууд хамтран гүйцэтгэнэ.

16.3. Морьдыг гарааны зурхайд зориулалтын төхөөрөмжийн араас даамлын дохиогоор нэгэн зэрэг эргүүлнэ.

24.4. Гарааны зурхайд хүрээгүй байхад морь эргүүлэх, замаас морь оруулахыг хориглоно. Зурхайд хүрч, даамлын дохиогоор эргээгүй болон замаас оруулсан морьдыг барихгүй.

17 дугаар зүйл. Уралдааны үеийн зохион байгуулалт

17.1. Үндэсний морин уралдаан зохион байгуулах комиссоос даамал, хүн эмнэлэг, мал эмнэлэг, цагдаагийн хамгаалалт, хэвлэл мэдээллийн тээврийн хэрэгсэлд уралдаан дагах зурвасыг тэмдэглэж, 8 хүртэлх зөвшөөрөл олгоно. Бусад зөвшөөрөл олгоогүй автомашин, мотоцикль уралдааныг дагахыг хориглоно. Тухайн уралдааны цар хүрээ, уралдаж байгаа морь, хүүхдийн аюулгүй байдал, хэв журмыг хангах үүднээс тээврийн хэрэгслийн тоог 4 хүртэл нэмж болно.

17.2. Уралдааны үед тухайн насны морьдын уралдааныг хариуцсан даамал төрийн далбааг мандуулан, эхний мориноос 200 метрээс холгүй зайд өмнө нь явж замчилна.

17.3. Хүн эмнэлгийн тусламжийн хэсэг морьдын ард явж мориноос уралдаанч хүүхдэд унасан тохиолдолд шаардлагатай тусламж үйлчилгээг яаралтай үзүүлнэ.

17.4. Мал эмнэлгийн тусламжийн хэсгүүд уралдааны замын дагуу тогтоосон цэгт байрлаж, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлнэ.

17.5. Уралдааны үед хүүхэд морьноос унах, уралдааны замаас морь гарах, гаднаас морь орж ирэх зэрэг болзошгүй үйлдэлд зохион байгуулагчид хяналт тавина.

17.6. Уралдах морийг зурхайд урьдчилан аваачих, замаас оруулах, хөөх, саад хийх, уралдаж байгаа морьдыг тосон цулбуурдаж хөтлөхийг хориглоно. Ийм тохиолдол гарсан үед тухайн морьдыг уралдаанаас хасна.

17.7. Уралдааны үед уралдаж байгаа морьдоос тэмдэглэсэн зурвасын дагуу хэвлэл мэдээллээс бусад тээврийн хэрэгсэл салхин дор дагана.

17.8. Морь тайлбарлах, дамжуулах хэвлэл мэдээллийн ажилтанууд комиссын зөвшөөрөлтэйгээр уралдаанд саад болохгүйгээр дагаж нэвтрүүлэг, бичлэг хийж болно.

17.10. Улсын баяр наадмын Үндэсний морин уралдааныг орчин үеийн дэвшилтэт техник технологийг ашиглаж бүрэн дамжуулна.

17.11. Энэхүү дүрмийн 17.1-т зааснаас илүү тээврийн хэрэгсэл уралдааныг 200 метрээс хол зайд, тэмдэглэсэн зурвасын дагуу зохих төлбөртэйгээр дагах зөвшөөрөл олгох эсэхийг зохион байгуулагчид шийдвэрлэж болно.

18 дугаар зүйл. Барианы үеийн зохион байгуулалт, морьдыг барих

18.1. Уралдааны морьдыг барианы зурхайн тэмдэглэсэн зураас дээр ирсэн дарааллаар барина.

18.2. Түрүү, айргийн таван морьдыг морь бариач барианы зурхай өнгөрснөөс хойш пайзаар, хойшхи морьдыг уралдаанч хүүхдэд олгосон дугаараар, дуу, дүрс бичлэгийн техник хэрэгсэл ашиглан цуваа дуудаж, барина.

18.3. Барианд зэрэгцэж ирсэн морьдоос аль нэгний нь хушуу илүү гарсан бол тэр морийг урд нь барих ба хушуу илүү гараагүй бол зөв талын морийг эхэлж барина.

18.4. Барианы зурхайд хүүхэдгүй ирсэн морийг таван байраар ухрааж барина.

18.5. Жолоог богиносгосон, дэл, сойлго, эмээлд нь уяж бэхлэх зэргээр зориуд санаатайгаар хүүхэдгүй ирүүлсэн морийг уралдаанаас хасна.

18.6. Түрүүлж, айрагдсан морьдыг уралдааны дараа цоллохоос өмнө нутгийн уугуул монгол үүлдрийн адуунд нийцээгүй болох нь баримттай тогтоогдсон эсхүл дахин шүдэлж, тухайн насны биш болох нь батлагдвал уралдаанаас хасч дараагийн нийцсэн морийг урагшлуулж барина.

18.7. Барианд орж байгаа морь, уралдаанч хүүхдэд санаатайгаар саад хийх, чирэх, сул морийг хэн нэгэн унаж барианд орох, уралдаанч хүүхэд морийг сэлгэж уралдахыг хориглоно.

18.8. Уралдсан морьдын 30 хүртэлх хувийг барьж, үнэмлэх олгоно.

18.9. Морь барианы маргаантай асуудлыг комиссын дарга, тухайн насны даамал, дэд даамал дуу, дүрс бичлэгийн техник хэрэгсэл ашиглан эцэслэн шийдвэрлэнэ.

18.10. Барианы газар айргийн морин хашаатай байна. Айргийн морин хашаанд үндэсний хувцастай морины эзэн, уяач, хэвлэл мэдээллийн ажилтан орж болно.

18.11. Барианы газрыг наадамчид, үзэгчидэд уралдааны үйл явцыг үзэхэд тохиромжтой, дуу дүрс бичлэгийн төхөөрөмж ашиглан шуурхай дамжуулан хүргэхээр зохион байгуулна.

19 дугаар зүйл. Морь цоллох, бай шагнал олгох

19.1. Түрүүлж, айрагдсан морьдыг уламжлалын дагуу цоллооч цоллоно. Цоллож байхад уралдаанч хүүхэд гийнгоолж, марзайлна.

19.2. Баяр наадамд түрүүлсэн, айрагдсан морьдыг эзэн, уяач, уралдаанч хүүхдийн нэрээр цоллон алдаршуулж, бай шагналыг наадамчдын өмнө олгоно. Нас тус бүрт уралдсан морьдын 30 хүртэл хувийг барьж, бай шагналыг уралдаан зохион байгуулсан өдрүүдэд багтааж зохион байгуулах комиссын байранд бүрэн олгоно.

19.3. Түрүүлж, айрагдсан моринд олгох бай шагналын 20-иос доошгүй хувь нь уралдаанч хүүхдэд олгоно.

19.4. Тухайн уралдаанд түрүүлж, айрагдсан морийг хувь хүн, байгууллага шагналын сангаас гадна нэмж байлж болно.

19.5. Бай шагналын хэмжээг нийтэд зарлан мэдээлсэн тохиолдолд өөрчлөхийг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НААДАМЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ

20 дугаар зүйл. Уяачийн эрх

20.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр зохион байгуулагдаж байгаа Монголын Үндэсний морин уралдааны дүрэмд заасан ангилалаар нутгийн уугуул монгол үүлдрийн адуугаа уяаж сойн уралдуулах эрхтэй.

20.2. Улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн цолонд тодорхойлогдох эрхтэй.

20.3. Үндэсний морин уралдааны дүрмийг зөрчсөн аливаа үйлдлийг засан залруулахыг комиссоос шаардах эрхтэй.

20.4. Уралдааны зохион байгуулалтын талаар санал, гомдлыг бичгээр гаргах, комиссоос зохих тайлбар авах, хариу авах эрхтэй.

20.5. Бүртгүүлсэн морио уралдуулахгүй байх эрхтэй.

20.6. Хүн, малын эмчийг дуудаж үйлчлүүлэх эрхтэй.

20.7. Хууль тогтоомжид заасан бусад эрхтэй.

21 дүгээр зүйл. Уяачийн үүрэг

21.1. Үндэсний морин уралдааны дүрэм, журам, холбогдох батлагдсан стандартыг дагаж мөрдөх үүрэгтэй.

21.2. Уясан морьдынхоо уяа сойлгыг зөв, сайн тохируулж, мориныхоо аюулгүй байдлыг хангаж уралдуулах үүрэгтэй.

22.3. Үндэсний их баяр наадам, Үндэсний морин уралдааны үндэсний уламжлалт соёлын өв болохыг гүнээ ухамсарлаж, хүндэтгэн эзэмших, даган биелүүлэх, уяачийн тангарагийг сахин биелүүлэх үүрэгтэй.

22.4. Үндэсний морин уралдаанд тохирсон ангилал болон бүртгүүлсэн нутгийн уугуул монгол үүлдрийн адуугаар уралдах үүрэгтэй.

22.5. Үндэсний морин уралдааны нутгийн уугуул монгол үүлдрийн адуутай гадаад улсын үүлдрийн адуугаар эрлийзжүүлсэн адуу болон цэвэр цусны адууг хольж уралдуулахгүй байх үүрэгтэй.

22.6. Өөрийн морины удам угшил, түүх, амжилт, унаган эзнийг үнэн зөв бүртгүүлж, мэдээлэх үүрэгтэй.

22.7. Хүүхдийнхээ эцэг, эх хууль ёсны асран хамгаалагч болон өөрөөс нь морь унаж уралдах зөвшөөрөл авсан байх үүрэгтэй.

22.8. Хүүхдийг гэнэтийн ослын даатгалд хамруулах үүрэгтэй.

22.9. Эмээл, тохош, олом, жирэм, угсуурга, дөрөөн сур, хазаарын жолоо, хэрэглэлийг сайн бөхөлж, хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалалтын стандарт хувцасыг өмсүүлэх үүрэгтэй.

22.10. Хүүхдийг ерөнхий боловсролын сургууль завсардуулахгүй байх үүрэгтэй.

22.11. Хүүхэд тухайн насны морийг унаж уралдахаас татгалзсан тохиолдолд мордуулахгүй байх үүрэгтэй.

22.12. Уралдааны үед холбооны техник хэрэгсэл ашиглан, уралдаанч хүүхдийг удирдах, зааварчилахыг хориглох үүрэгтэй.

22.13. Үндэсний морин уралдааны дүрмийн холбогдох заалтыг хүүхдэд сайтар тайлбарлаж өгөх

22.14. Уясан морьдоо зарласан цагт бүртгүүлж, уралдааны хөтөлбөрийн дагуу тогтоосон цагт мордуулах

22.15. Нийгмийн хэв журмыг сахиж, наадмын дэг жаягийг хатуу баримтлан, зохион байгуулах комиссын шаардлагыг биелүүлэх

22.16. Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх буруу дадалтай, зүгшрээгүй морьдийг уралдаанд оролцуулахгүй байх

22.17. Уралдах адууныхаа удам угшил, гарвалыг худал мэдүүлсэн бол залруулахад гарсан зардал, учирсан хохиролыг хариуцан төлөх, олгосон бай шагнал, морины медалыг зохион байгуулах комисс буцаан өгөх үүрэгтэй.

23 дугаар зүйл. Хүүхдийн эрх

23.1. Үндэсний морин уралдаанд хүүхэд нь сайн дурын үндсэн дээр морь унаж уралдах

23.2. Морь унаж уралдсаны төлөө уяачаас зохих урамшуулал авах

23.3. Уралдааны замд эмээлийн олом, жирэм сулрах зэрэг бусад шаардлага гарвал зохион байгуулах комисст хэлж тусламж авах

23.4. Эцэг эх, асран хамгаалагч нь морь унахыг зөвшөөрсөн боловч хүүхэд өөрөө тухайн морийг унахаас татгалзах

23.5. Стандартын хамгаалалтын хувцас, хэрэглэлээр хангахыг уяачаас шаардах

23.6. Уралдаанч хүүхдийн спортын цол, зэрэг авах

23.7. Хууль тогтоомжид заасан бусад эрх

24 дүгээр зүйл. Хүүхдийн үүрэг

24.1. Үндэсний морин уралдааны дүрмийг дагаж мөрдөх.

24.2. Зохион байгуулах комиссын тавьсан шаардлагыг биелүүлэх.

24.3. Үндэсний их баяр наадам, үндэсний морин уралдааны уламжлалт ёс заншил, соёлын өвийг ухамсарлаж, хүндэтгэн эзэмших, даган биелүүлэх

24.4. Үндэсний уламжлалт гийнгоо, марзайг сурах, хэрэглэж хэвших

24.5. Гарааны зурхайд хүрч, зориулалтын гарааны төхөөрөмжийн араас даамлын дохиогоор нэгэн зэрэг гараанаас гарах

24.6. Уралдааны явцад зам товчлохгүй, арын морийг хаахгүй, барианы зурхай дээр хажуугийн моринд саад хийхгүй байх

24.7. Уралдааны замд бусадтай хэрэлдэх, зодолдох, бусад хүүхэд болон морьдод аюултай үйлдэл хийхгүй байх /олом тайлах, ташуураар ороолгох гэх мэт/

24.8. Гарааны зориулалтын төхөөрөмж рүү орохдоо морио зөөлөн алхуулж орох

24.9. Тангардаг морьтой бол бусад уралдаанч хүүхдэд урьдчилан хэлж сануулж явах


24.10. Уралдахдаа 60 см-аас илүүгүй ташууртай байх

24.11. Уралдааны замд морин давхил илт суларч, багтарч байвал морио татан авч цаашид уралдуулахгүй байх, уралдааны замыг чөлөөлөх

25 дүгээр зүйл. Наадамчдын эрх, үүрэг

25.1. Үндэсний их баяр наадам, үндэсний морин уралдааны уламжлалт соёлын өв болохыг гүнээ ухамсарлаж, хүндэтгэн эзэмших, даган биелүүлэх үүрэгтэй

- 25.2. Уяач, уралдаанч хүүхэд, уралдсан морио хүндэтгэх, барианы зурхай руу дайрч, морьд барианд ороход саад учруулахгүй байх
25.3. Үндэсний морин уралдааныг дагахгүй байх
25.3. Наадмын талбайд нийгмийн хэв журам сахих,
25.4. Зохион байгуулах комиссын баталсан журмыг дагаж мөрдөх



26 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллага, ажилтны эрх, үүрэг

- 26.1. Үндэсний морин уралдааны талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд түгээх, сурталчилах эрхтэй.
26.2. Үндэсний морин уралдааны дүрмийг судалж, зохион байгуулах комиссын шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
26.3. Үндэсний морин уралдааны үйл явц, зохион байгуулалтанд саад, хүндрэл бэрхшээл учруулахгүй байх
26.4. Уралдаж байгаа морьдоо тэмдэглэсэн, зөвшөөрсөн зурвасын дагуу дагах үүрэгтэй.
26.5. Уралдаан зохион байгуулах комиссоос өгсөн албан ёсны мэдээлэлд тулгуурлан олон нийтэд үнэн зөв, бодитой, тэнцвэртэй мэдээлэл түгээх үүрэгтэй.
26.6. Үндэсний морин уралдаан тайлбарлагч нь тайлбар хийхдээ уяач, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдсан үг хэллэг, нэр хоч хэрэглэхгүй байх.
26.6.1. Адууны удам угшил, түүх, амжилтыг худал мэдээлэхгүй байх
26.6.2. Үндэсний уламжлалт ёс заншилд харш үг хэллэг хэрэглэхгүй байх

ТАВДУГААР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ МОРИН УРАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ

27 дүгээр зүйл. Үндэсний морин уралдааны санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

- 27.1. Улсын болон орон нутгийн төсөв
27.2. Үндэсний холбооны төсөв
27.3. Хандив, тусламж
27.4. Бүртгэлийн хураамж
27.5. Бусад

28 дугаар зүйл. Үндэсний морин уралдаан зохион байгуулагч төсвөө өөрөө хариуцна.

29 дугаар зүйл. Төвлөрсөн төсвийг зөвхөн үндэсний морин уралдааныг зохион байгуулахад зарцуулна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ МОРИН УРАЛДААНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

30 дугаар зүйл. Уралдааны зам

- 30.1. Уралдааны зам нь хүүхэд, уралдах морины аюулгүй байдлыг бүрэн хангахуйц, морины давхил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээргүй уралдааны замыг сонгох, засварлах, тэмдэг тэмдэглэгээ хийж байршуулна.
30.2. Уралдааны замд хэт өндөр даваа, өргөн гол горхи, огцом эргэлт, гуу жалга, хальтиргаа гулгаа, шавар, гүнзгий хөндлөн зам, үлийн нүх байх нь тохиромжгүй.

30.3. Уралдаан зохион байгуулах комисс уралдааны замын эрсдэл бүхий хэсгийг засаж, аюулгүй байдлыг ханган уралдаанд бэлтгэнэ.

30.5. Уралдааны замд саад учруулах мал, амьтан, зорчигчийг зохион байгуулах комисс замаас чөлөөлнө.



31 дүгээр зүйл. Гарааны зориулалтын төхөөрөмж

31.1. Шаардлага хангах төмөр материалаар зангидаж, бат бөх олон давхар тортой, өндөр нь 2 метрээс багагүй, уралдах морьд багтах урттай, нэгэн зэрэг нээгдэх боломжтой байна.

31.2. Үндэсний морин уралдаан зохион байгуулахад гарааны зориулалтын төхөөрөмжтэй байна.

32 дугаар зүйл. Уралдааны үеийн аюулгүй байдал

32.1. Уралдааны явцад зохион байгуулах комиссын зөвшөөрөлгүй уралдааныг тээврийн хэрэгсэлээр дагах, хүнгүй нисдэг дүрс бичлэгийн тоног төхөөрөмж (дрон)-өөр зөвшөөрөлгүй бичлэг хийхийг хориглоно.

32.2. Бусад аюулгүй байдлыг энэхүү дүрмийн холбогдох бусад заалтуудаар зохицуулагдана.

ДОЛДУГААР БҮЛЭГ ДҮРЭМ, ЖУРАМ ЗӨРЧСӨН ЭТГЭЭДЭД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

33 дугаар зүйл. Энэхүү дүрэм, тухайн уралдааны журмыг зөрчсөн уяачид тухайн шатны холбооны Ёс зүйн зөвлөл дор дурдсан шийтгэлийг хүлээлгэнэ.

33.1. тухайн уралдааны амжилтыг хүчингүйд тооцох

33.2. Холбооны шагналууд, оны шилдгүүдэд шалгаруулахгүй байх

33.3. Холбооны удирдлагын бүтцэд нэр дэвших, сонгогдох эрхийг 2 жил хүртэл хугацаагаар хасах

33.4. Уралдаанд тухайн мориор оролцох эрхийг хасах

33.5. Уралдаанд оролцох эрхийг 2 жил хүртэл хугацаагаар хасах

34 дугаар зүйл. Энэхүү дүрмийн 33.1, 33.4, 33.5 -т заасан шийтгэлийг үндэсний морин уралдаан зохион байгуулах комисс хүлээлгэж болно.

35 дугаар зүйл. Энэхүү дүрэм, тухайн уралдааны журмыг зөрчсөн зөрчил, хариуцлага хүлээсэн уяач, бүртгэлээс хасагдсан морины талаарх болон шаардлагатай бусад мэдээллийг цахим вэб хуудсанд ил тод байршуулан, олон нийтэд мэдээллэнэ.

36 дүгээр зүйл. Энэхүү дүрэм, тухайн уралдааны журмыг Үндэсний морин уралдааны зохион байгуулах комиссын дарга, гишүүдэд дараах хариуцлагыг тухайн шатны холбооны Ёс зүйн зөвлөл хүлээлгэнэ.

36.1. Зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээс хасах, дахин комисст томилохгүй байх

36.2. Холбооны тэргүүлэгч гишүүнээс чөлөөлөх

36.3. Холбооны гишүүнчлэлээс хасах

36.4. Учирсан хохирлыг нөхөн төлүүлэх

37 дугаар зүйл. Уяач, уралдаанч хүүхэд, комиссын дарга, гишүүд тухайн шатны холбооны Ёс зүйн зөвлөлийн шийтгэлийг эс зөвшөөрвөл дээд шатны холбооны ёс зүйн зөвлөлд нэг удаа гомдол гаргах эрхтэй.

38 дугаар зүйл. Дээд шатны Ёс Зүйн зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Монголын олон улсын ба үндэсний спортын арбитр, эсхүл шүүхэд хандах эрхтэй.

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МОРИН УРАЛДААН, УЯАЧДЫН ХОЛБОО
НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**